

Шүүгчийн сайн сайхан байдлын тухай Науругийн тунхаг

Авлигын эсрэг Нэгдсэн Үндэстний байгууллагын Конвенцийн 11 дүгээр зүйлд, Оролцогч улс бүр шүүхийн хараат бус байдал, авлигын эсрэг тэмцэлд шүүхийн шийдвэрлэх үүрэгтэйг харгалзан шүүгч, шүүхийн байгууллагад ажиллагсдын үнэнч шударга байдлыг бэхжүүлэх, тэдгээрийн дунд авлигад автагдах боломж бий болохоос урьдчилан сэргийлэх арга хэмжээг эрх зүйн тогтолцооныхоо тулгуур зарчимд нийцүүлэн, шүүхийн хараат бус байдалд хохирол учруулахгүйгээр авна. Эдгээр арга хэмжээнд шүүгч, шүүхийн байгууллагад ажиллагсдын ёс зүйн дүрмийг багтааж болно.

Нэгдсэн Үндэстний байгууллагын Гэмт хэрэг, мансууруулах бодистой тэмцэх газар нь (UNODC-НҮГХМБТГ)-ийн гишүүн орнуудад уг Конвенцийг үр дүнтэй хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилготой бөгөөд гишүүн орон тэдгээрийн шүүхийн байгууллагуудын туршлага солилцох, шүүхийн үйл ажиллагаа дахь шударга ёс, ёс зүйн асуудлыг хамтран шийдвэрлэх зорилгоор Шүүхийн ёс зүйн сүлжээг байгуулсан.

Нэгдсэн Үндэстний байгууллагын Гэмт хэрэг, мансууруулах бодистой тэмцэх газар (UNODC) болон UNODC-ийн Шүүхийн ёс зүйн сүлжээ нь Авлигын эсрэг Нэгдсэн Үндэстний байгууллагын Конвенцийн 11 дүгээр зүйлийн хэрэгжилтийг хангах чиглэлд Авлигын эсрэг Конвенцийн хэрэгжилтийн үнэлгээний гарын авлага, мөн Шүүхийн сайн сайхан байдал болон ёс зүйн холбооны тайлан зэргийг боловсруулсан.

Эдгээр нь авлигын эсрэг үйл ажиллагааг дэмжих, ёс зүйн стандартыг бэхжүүлэх, мөн шүүхийн сайн байдлыг хангахад дэмжлэг үзүүлэх зорилго бүхий юм.

(UNODC)-аас хийсэн олон улсын нөхцөл байдлын талаарх судалгааны тайлангийн үр дүн болон шүүхийн стресс дарамт, сайн сайхан байдлын талаар хууль эрх зүйн хүрээнд хийсэн бусад судалгааны үр дүнд дэлхийн хэмжээнд шүүх байгууллагуудын ажлын байран дахь стрессийн түвшин өндөр, хүлээн зөвшөөрөгдөх байдал бага байгааг харуулж байна.

Шүүхийн үйл ажиллагааны сайн сайхан байдал нь Шүүгчийн ёс зүйн Бангалорын зарчимд тусгагдсан дараах зургаан үндсэн үнэт зүйлсийн баталгааг нэгэн адил хангана. Үүнд:

- Хараат бус байдал
- Төвийг сахих байдал
- Шударга байдал
- Зохистой байдал
- Тэгш байдал
- Ур чадвар ба хичээл зүтгэлтэй байдал

Шүүхийн байгууллага нь чиг үүргээ үр дүнтэйгээр, аливаа зүй бус нөлөөллөөс ангид биелүүлэхэд шаардлагатай хүний нөөцийг бүрдүүлж, хараат бус, бие даасан байдлаар ажиллана. Шаардлагатай материаллаг нөөц болон мэргэшсэн хүний нөөцийг бүрдүүлэхээс гадна тухайн ажилтныг чиг үүргээ гүйцэтгэхэд нь шаардагдах мэдлэг, ур чадвар, бэлтгэлээр хангах нь зүй.

Шүүх эрх мэдлийн тогтолцоо нь олон талт, хүртээмжтэй болж байгааг сайшааж, энэхүү олон талт байдал нь шүүхийн тогтолцоог улам бэхжүүлж, шүүхэд итгэх олон нийтийн итгэлийг нэмэгдүүлж байгааг хүлээн зөвшөөрөх нь зүй.

Шүүгчийн ёс зүйн Бангалорын зарчмын 194 дүгээр зүйлд “...Шүүгч нь биеийн болон сэтгэцийн эрүүл мэндээ хамгаалах хангалттай хугацаа төдийгүй, шүүн таслах ажиллагааг үр дүнтэй гүйцэтгэхэд шаардлагатай мэдлэг, ур чадвараа хөгжүүлэх бодит бололцоогоор хангагдах ёстой. Шүүгчийн ажил стресс ихтэй ажил гэдэг нь нэгэнт хүлээн зөвшөөрөгдсөн зүйл” хэмээн заасан нь шүүгч түүний стрессийг бууруулахад зохих дэмжлэг үзүүлэх шаардлагатайг харуулж байна.

Шүүх засаглалын болон бусад эрх зүйн салбарын төлөөлөгчид 2024 оны 7 дугаар сарын 25-нд Науру улсын Иргэний төвд хэлэлцэж, дараах тунхаглалыг гаргасан нь:

Шүүгчийн сайн сайхан байдлын тухай Науругийн тунхаг

- 1. Шүүгчийн сайн сайхан байдлыг хангах нь эн тэргүүний бөгөөд үүнийг хүлээн зөвшөөрч, дэмжих хэрэгтэй.**

Шүүгчийн сайн сайхан байдал гэдэг нь нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн сайн сайхан байдлын хэмжүүр буюу оюун санаа, сэтгэлзүй, бие махбодын зэрэг амьдралын бүхий л талбарт хөгжих боломжийг олгож, тасралтгүй сайжруулах үйл явц юм. Энэ нь зөвхөн шүүгчийн эрүүл мэнд, тогтвортой байдлыг хангахаас гадна шүүхийн ил тод нээлттэй байдлыг хангах, шүүхийн үйлчилгээнд олон нийтийн хяналтыг бий болгох хийгээд шүүхэд итгэх олон нийтийн итгэлийг нэмэгдүүлэхэд чухал ач холбогдолтой.

Иймээс шүүгч түүний сайн сайхан байдал нь шударга ёсны хүртээмж, шүүгчийн үнэт зүйлсийг хадгалах, шүүгчийн сургалт, шүүхийн үр ашигтай байдлыг бусад байгууллагын тэргүүлэх зорилтуудтай уялдуулан бэхжүүлэх, анхаарал, хөрөнгө оруулалтыг шаардана.

- 2. Шүүгчийн ажлын стресс нь сул тал болох ёсгүй.**

Шүүгчийн стресс нь түүний ажил үүргийн ачааллаас үүдэлтэй сөрөг сэтгэл зүй, бие махбодын болон зан үйлийн хариу урвал юм. Үүнийг сул дорой байдлын илэрхийлэл гэж үзэх хандлагатай тул удирдлагын зүгээс эерэг соёлыг хөгжүүлэхэд анхаарах ёстой.

- 3. Шүүгчийн сайн сайхан байдал нь шүүгч болон шүүхийн байгууллагуудын хамтын хариуцлага юм.**

Шүүгчид өөрсдийн сайн сайхан байдлыг хадгалах, бэхжүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэх үүрэгтэй бол шүүхийн удирдлага нь ажиллах таатай орчин нөхцлийг бүрдүүлэх үүрэгтэй.

- 4. Шүүгчийн ёс зүй, харилцаа хандлага нь сайн сайхан байдлыг бүрдүүлэх чухал элементүүдийн нэг.**

Хамт олонч уур амьсгал нь шүүгчийн сайн сайхан байдлыг бэхжүүлэх гол хүчин зүйл юм. Шүүгч нь бусдад давуу байдал олгох, шударга бус хандах, ялгаварлан гадуурхах байдлаас ангид байх зарчмыг баримтлах ёстой.

- 5. Шүүгчийн сайн сайхан байдлыг нэмэгдүүлэхэд мэдлэг, ур чадвар олгох, урьдчилан сэргийлэх, зохицуулах арга хэмжээ шаардлагатай.**

Шүүхийн удирдлага нь шүүгчийн сайн сайхан байдлыг ямагт дэмжих үүрэгтэй. Энэхүү хандлага нь ажлын байран дахь дарамт, стресс үүсгэж буй шалтгааныг илрүүлэх, түүнийг бууруулах, нотолгоонд суурилсан арга хэмжээг хэрэгжүүлэхэд чиглэх ёстой.

- 6. Шүүгчийн сайн сайхан байдлын төлөөх аливаа санаачилга, арга хэмжээ нь улс орон бүрийн онцлогт тохирсон байх ёстой.**

Шүүгчийн сэтгэл зүй, сайн сайхан байдалд нөлөөлөх хүчин зүйлс нь улс орон бүрийн эдийн засаг, нийгэм, соёл, улс төр, шашин, байгаль орчны нөхцөл байдлаас хамаарал бүхий байна.

- 7. Хүний эрхийн үзэл санаа шүүгчийн сайн сайхан байдлыг бэхжүүлнэ.**

Бангалорын зарчимд зааснаар, шүүгчид үзэл бодлоо илэрхийлэх, эвлэлдэн нэгдэх зэрэг суурь эрхүүдийг эдлэх ч, тэдгээрийг шүүхийн нэр хүнд, шударга ёс, бие даасан, хараат бус байдалтай нийцүүлэн хэрэгжүүлэх нь чухал юм.